



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/32

Шивээговь сум

□ Хяналтын цэг байгуулж, ажиллуулах
тухай □

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.в, 29.1.6.а, б, л, 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.8, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1, 11.2.3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 10 дугаар зарлиг, Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 05 дугаар хуралдааны шийдвэр, аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/63 дугаар захирамж, сумын Онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 04 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг түр зогсоосонтой холбогдуулан сумын төвөөс орох, гарах хөдөлгөөнийг хянах хяналтын цэгийг 2020 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 08:00 цагаас 02 дугаар сарын 27-ны өдрийн 08:00 цаг хүртэлх хугацаанд ажиллуулсугай.

2. Хяналтын цэгийн байршлыг хавсралт ёсоор баталсугай.

3. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас /ар гэрийн гачигдал, эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ, албан томилолт, ажлын зайлшгүй шаардлага гэх мэт/ зорчих төрийн албан хаагч, иргэдийн нотлох баримтыг үндэслэн хүндрэл чирэгдэл учруулахгүйгээр нэвтрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг сумын Цагдаагийн хэсгийн дарга, онцгой комиссын гишүүн, цагдаагийн хошууч /Ц.Баасанжав/, Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, шуурхай штабын дарга /Б.Баасанбат/ нарт үүрэг болгосугай.

4212 0076

4. Хяналтын цэгт ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулж, төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэн ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, онцгой комиссын орлогч дарга /Б.Баасанбат/-д үүрэг болгосугай.

5. Хяналтын цэгт ажиллаж байгаа ажилтнуудын аюулгүй байдлыг хангаж, эм эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодис, амны хаалтаар хангаж ажиллахыг байгууллагын дарга, захирал, эрхлэгч, онцгой комиссын гишүүдэд тус тус даалгасугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч, Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дарга /Ж.Батмөнх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ

Сумын Засаг даргын 2020 оны 02-р сарын 21-ны өдрийн 7/32 дугаар захирамжийн хавсралт



ХЯНАЛТЫН ЦЭГИЙН БАЙРШИЛ

№	Хяналтын цэгийн дугаар	Байршил	Жижүүрлэх албан хаагчид
1.	I	Төв зам	1. Цагдаагийн хэсгийн хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Зориг-Эрдэнэ 2. Цагдаагийн хэсгийн зохицуулагч, цагдаагийн ахлах дэслэгч Д.Өнөржаргал 3. ЗДТГ
2.	II	Сумын төвийн урд хэсэг	1. Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч Ц.Баасанжав, 2. Цагдаагийн хэсгийн цагдаа, жолооч М.Анх-Эрдэнэ 3. ЗДТГ
3.	III	Сумын төвийн хойд хэсэг	1. Цагдаагийн хэсгийн жижүүрийн цагдаа, сургагч, ахлагч Ш.Батмөнх 2. Цагдаагийн хэсгийн жижүүрийн цагдаа, дэд ахлагч Г.Ууганбаатар 3. Ерөнхий боловсролын сургууль
4.	IV	Уурхай, 22-р зөрлөгийн салдаг хэсэг	Шивээ-Овоо хувьцаат компани

ХЯНАЛТЫН ЦЭГҮҮДЭД ХЯНАЛТ ТАВИХ ХУВААРЬ

№	Хяналт тавих албан хаагчийн овог нэр, албан тушаал	Хяналтаар явах сар, өдөр
1.	Сумын Засаг даргын орлогч Ж.Батмөнх, Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч Ц.Баасанжав	II/23
2.	ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Баасанбат, Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч Ц.Баасанжав	II/24
3.	ИШОНӨҮГ-ын захирал Ү.Даваасүрэн, Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч Ц.Баасанжав	II/25
4.	ЗДТГ-ын Санхүүгийн албаны дарга У.Чулуунцэцэг, Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч Ц.Баасанжав	II/26